

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого" цахим сургалтанд сумын хэмжээнд 103 Төрийн албан хаагч хамрагдаж сертификатаа авсан. МАЛЧДЫН ЗӨВӨЛГӨӨН-ТЭМЭЭНИЙ УРАЛДААН-ыг 3-р сарын 1 нд зохион байгуулж, нийт 8 багийн 150 гаруй малчин, 8 –н албан байгууллага оролцсон. . Зөвөлгөөнд оролцогчдын 100 хувийн саналаар Тэмээчдийн холбоотой болох шийдвэр гарсан. Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгох төслийн зарыг 2023 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01 хүртэл зарлаад Эрдэнэцагаан веб сайт, ЗДТГ-ын пейж хуудсаар дамжуулан бусад сумын 4 группуудээр болон байгууллагын ил тод мэдээллийн самбар, төрийн үйлчилгээний нэгдсэн төв зэргээр дамжуулан иргэдэд тогтмол хүргэж ажиллаж байна.

ЕБС: Аймгийн хэмжээнд Улсын төрөлжсөн олимпиадыг танхим цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгууллагдаж, Түүхийн багшийн төрөлд Б.Энхтүвшин 2-р байр мөнгөн медаль, Удаанхүү 4-р байр эзэлж амжилттай оролцлоо. УНШЪЯ-СЭТГЭЕ-ХӨГЖЬЕ унших чадварын уралдаан 2-5 ангид амжилттай зохион байгууллаа.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын харъяа хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, алтан гадас одонт, спортын мастер Батсүхийн Загдрагчаагийн нэрэмжит ААШ жудо бөхийн өсвөр үеийн тэмцээнд алт 4, мөнгө 4, хүрэл 6, шилдэг эмэгтэй тамирчин 1, Багаараа 3-р байр эзлэн амжилттай оролцсон.

Гүрэн академиас бүртгэл бүсчилэн хийж байгаатай холбогдуулан Англи хэлний багш нар онлайн сургалтанд хамрагдсан. Astrid 265 сурагч бүртгүүлсэн.

Орон нутгаас дэлхийрүү төслийн хүрээнд "Azia mongolia" ТББ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан "Code cub" клубын өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн хүрээнд Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор "Өсвөрийн номын санч" клубын сурагчид III/06-III/10-ны өдрүүдэд Сурагч пост үйл ажиллагааг эхлүүлж сургуулийн орчин дахь сурагчдын дэг журмыг сахиулж, мэндлэх хүндлэх ёсыг хэвшүүлэн ажиллалаа.

Аймгийн аварга шалгаруулах "САГСАН БӨМБӨГ"- ийн насанд хүрэгчдийн тэмцээнд Б.Гантулга багшийн дасгалжуулсан баг хамт олон мөнгөн медаль хүртэж амжилттай оролцлоо.

ЭМЯ-аас Эрүүл жиндээ аяныг үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан байгууллагынхаа багш ажилчид руу чиглэсэн ажлын байрын дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэхээр ажиллауж байна.

Соёлын ажлын хүрээнд:

Эх орончдын өдрөөр сумын ЗДТГ хамтран МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН 2023 малчин залуусын чуулга уулзалт , малчин залуусын дунд ДӨРВӨН БЭРХ тэмцээнийг амжилттай зохион байгуулж Тэмцээнд нийт 8 багийн 80 залуу малчид хурд хүч авхаалж самбаагаа сорин оролцлоо. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан МОНГОЛ УХААН ардын уламжлалт зан заншил, ахуй соёлоо сурталчилах арга билэг ухаан сорьсон 5 төрөлт тэмцээн "Эрхэмсэг ээжүүд"- хөтөлбөрт Үдшийн цэнгүүнийг зохион явуулж нийт 120 орчим иргэд хамрагдсан.

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх ажлын хүрээнд:

НҮБ ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч Эваристе Коуасси Комланы хэрэгжүүлж буй төслийн хүрээнд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн #ЧИП багцыг хүлээн авсан.

Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

- “Засаг даргын тамгын газар” пэйж хуудасаар дамжуулж цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэлж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллаа.

E-Mongolia.mn, Төрийн үйлчилгээний цахим системийн хүрээнд:

Д/д	Үйлчилгээний тоо			Хамгийн их үзүүлсэн 10 үйлчилгээ	
	Нийт	Төлбөртэй	Төлбөргүй	Нэр	Тоо
1	2		Төлбөргүй	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	9
2			Төлбөргүй	Иргэний үнэмлэхийн лавлагаа	2

Нийт	0	2		11
------	---	---	--	----

Eg.e-mongolia.mn Төрийн байгууллагуудын цахим системийн хүрээнд:

- Төрийн цахим шуудан үйлчилгээний судалгаа гаргаж албан хэрэгцээнд ашиглахгүй байгаа хаягийг усгуулж ажилласан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

- Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 6953 нийт хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн яаралтай, нэн яаралтай тусламж үйлчилгээг ДЭМБ-ын хэнийг ч орхигдуулахгүй зарчимаар чанартай жигд хүртээмжтэй хүргэн ажиллаж байна. **Анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр :**

Хүн амд урьдчилан сэргийлэх болон идэвхитэй хяналтын үзлэгийг эмч нарын үзлэгийн хуваарийн дагуу нийт-**81**

Өвчний учир амбулатор-**439**

Хүнд үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэгт-**100**

Идэвхитэй хяналтаар-**81**

Гэрийн идэвхитэй үзлэг-**51**

Гэрийн дуудлага- **116**

Стационараар- **48** нийт хүнийг хэвтүүлэн эмчлүүлээд байна.

Нас баралт-3 Үүнээс:

Эмнэлгийн нас баралт-1

гэрт нас барсан- 2

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 0,

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах өвчнийг эрт илрүүлэн, эмчлэн эрүүлжүүлэх чиглэлээр нөхөн үржихүйн насны 1729 эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 55 эмэгтэй хамрагдаж үзлэгийн хувь 31,4 %байна. Жирэмсний хяналтанд 26 эх хянагдаж байгаа ба үүнээс өртөмтгий бүлгийн 8 жирэмсэн эх хяналтанд байна. "ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ" аяны арга хэмжээг зохион байгуулж, энэхүү арга хэмжээнд 180 иргэн хамрагдав.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Баянхонгор аймгийн Баянлиг сумтай Монгол тэмээ-адуу солилцоог амжилттай хийж гүйцэтгэлээ. Суманд 12 толгой 2-4 насны 7 охин, 5 эр /буур/ тэмээ ирж 12 10 өрх айл авсан. Баянхонгор аймгийн Жинст суманд болсон тэмээчдийн зөвөлгөөнд оролцсон талаарх мэдээллийг сумын малчдад танилцуулсан. Сумын хэмжээнд төл малын мэдээ, малын хорогдлын мэдээ, малын шилжилт бүртгэлийн шинэчилсэн программыг 8 багийн Засаг дарга нартай хамтран шинээр суулгаж ажилдаа нэвтрүүлэн ашиглаж эхэллээ. Багуудаас ирсэн судалгаагаар гадны өөр аймаг сумдаас 19 өрх 17650 толгой мал ирж өвөлжиж байна. /2022 онд Малчдын өргөдөл гомдолын дагуу 4,6-р багуудад 11-р сарын 1 нд багийн засаг дарга, мал эмнэлгийн тасгийн байцаагч, онцгой байдлын газрын ажилтан зэрэг 5 хүний бүрэлдэхүүнтэй хамт ажиллаа. Зөвшөөрөлгүй буусан 13 өрх айл /20-оод мянган толгой мал/ ирж нутгийн малчдын өвөлжөө хаваржааны ойролцоо буусан өрхүүдэд нутаг чөлөөлөх мэдэгдэх хуудас өгсөн.

Гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр

Аймгийн ГБХЗХГ-аас ГБХ-тэй холбоотой кейс ирсэний дагуу үйлчлүүлэгчтэй холбогдож холбогдох нөхцөл байдлын үнэлгээг болон ярилцагын тэмдэглэл хийж хяналтанд аваад ажиллаж байна. Хүүхэдтэй холбоотой ирсэн 1 гомдлын дагуу ЕБС дээр очиж хүүхэдтэй ярилцлагын тэмдэглэл болон хүүхдийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг хийж АУБ-тай нь уулзаж ярилцав. ЕБС-иас эрсдэлтэй гэж үзсэн 169 хүүхдүүдийн судалгааг авч эрсдлийн программд шивж оруулав.

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.